



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г.корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022. 05. 13 № 927
таний -ны № -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч иргэн Цогт-Очирын Баярцогтын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, нийслэлийн 2022-2023 оны төсвийн төсөөлөл, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Цогт-Очирын Баярцогтын дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Ц.БАЯРЦОГТ ТАНАА

Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Цогт-Очирын Баярцогтын сонгуулийн мөрийн хөтөлбөр /.... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сонгинохайрхан дүүргийн Сонгуулийн хороонд.

Хавсралт:  худастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

**УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРЭГ**

**БИЕ ДААГЧ
ЦОГТ-ОЧИРЫН БАЯРЦОГТЫН**

**МОРИЙН
ХӨТӨЛБӨР**

2022 он



[Signature]

ГАРЧИГ

1. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО
2. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГО
3. БОЛОВСРОЛЫН БОДЛОГО
4. СОЁЛ, СПОРТЫН БОДЛОГО
5. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГО
6. ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГО
7. ДЭД БҮТЭЦ
8. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО
9. НУТГИЙН ЗАХИРГААНЫ ХҮРЭЭНД
10. ХУНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД



1117145633
УХД0612 9077278

ЛЧ

**УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД БИЕ
ДААН НЭР ДЭВШИГЧ**

ЦОГТ-ОЧИРЫН БАЯРЦОГТЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Эрхэм зорилго:

“ХЯНАЛТЫГ АРД ТҮМНИЙ ӨМНӨӨС”

Хөтөлбөрийн зорилго:

Нэг. Иргэдийн үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг хангаж хувь хүний хөгжил төлөвшлийг дээшлүүлж, иргэдийн амьдралд дэвшил, өөрчлөлтийг авчирна.

Хоёр. Иргэдийн суурь хэрэгцээ, нийгмийн идэвхэд сууринсан хөгжлийн бодлогоор дүүрэг, хороо, хэсгээ хөгжүүлнэ.

Гурав. Төрийн ил тод, шуурхай үйлчилгээг төлөвшүүлнэ.

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

1.1. Нийслэл, дүүргийн алсын болон дунд, богино хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллана.

1.2. Дүүрэг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж, төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх явцад иргэд, олон нийтийн оролцоог хангаж ажиллана.

1.3. Төрийн сангийн нэгдсэн тогтолцооны дотоод хяналт, аудит сайжруулан, аудитын дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

1.4. Орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэн, баяжуулж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулна.

1.5. ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнтэй ажиллуулж, ашигт ажиллагааг дээшлүүлж, удирдлага зохицуулалтаар хангана.

1.6. Иргэд, аж ахуйн изгжид үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэн нийгмийн хариуцлагын санаачилгыг дэмжин иргэдэд мэдээллийг ил тодоор хүргэнэ.

1.7. Нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлтгэй болгож, хууль, журмын дагуу зохион байгуулна.

ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГО

2.1. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хөгжлийн талаарх хүсэлтийг төрийн захиргааны байгууллагуудад уламжлан ажиллана.

2.2. Өрхийн эрүүл мэндийн төвийн ажиллагсдын ёс зүйг сайжруулна.

2.3. Эрүүл мэндийн анхан шатны болон нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх боломжийг дээшлүүлнэ.



2.4. Эмч, эмнэлгийн ажилтны мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшилүүлж, ёс зүйн хариуцлагыг өндөржүүлнэ.

2.5. Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшилүүлэхэд анхааран ажиллаж, зорилтот бүлэгт эрүүл мэндийн зөвлөмж тусламжийг хүргэх багийг бүрдүүлнэ.

2.6. Нийтийг хамарсан цар тахал зэрэг өвчлөлийн үед удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллана.

ГУРАВ. БОЛОВСРОЛЫН БОДЛОГО

3.1. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарыг сайжруулахад бодлогоор дэмжиж ажиллана.

3.2. Ерөнхий боловсролын сургуулийн лабораторийг орчин үеийн техник хэрэгслээр хангах, сурагчдын мэдлэг чадварыг дээшилүүлэхэд анхаарна.

3.3. Хичээл, сургалтаас гадуурх сонгон секц, дугуйлангийн чанарыг сайжруулж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлж улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжиж ажиллана.

3.4. Хүүхдийг номтой нөхөрлүүлэх, өөрийг нээн хөгжүүлэх зорилготой арга хэмжээнүүдэд сурагчдыг идэвхтэй оролцуулахыг дэмжинэ.

3.5. Тусгай хэрэгцээт хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нөхцөлийг бүрдүүлж хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

3.6. Сургууль, цэцэрлэгүүдийн орчны тохижилтыг стандарт шаардлагад нийцэж буй эсэх дээр анхаарал хандуулан ажиллана.

3.7. Хүүхдийг тодорхой зорилго чиглэлтэй амьдрах, эх орноо хайрлах үзэл баримтлалаар хүмүүжүүлж, нийгэмд зөв иргэн болж төлөвшүүлэхэд анхаарч хүүхэд, гэр булийн хөгжил, хамгааллын үйлчилгээг сайжруулна.

3.8. Хүүхдийн эрүүл агаарт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор стандартын шаардлага хангасан хүүхдийн тоглоомын талбайг бий болгож орчныг бүрдүүлэхэд дэмжиж ажиллана.


ДӨРӨВ. СОЁЛ, СПОРТЫН БОДЛОГО

4.1. Соёлын салбарт ажиллагсдын мэдлэг чадварыг тасралтгүй дээшилүүлэн, мэргэжлийн ажилтнаар ханган, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

4.2. Соёлын байгууллагын хөгжлийн асуудлыг холбогдох төр захиргааны төв байгууллагуудтай уламжлан ажиллана.

4.3. Номын сангийн үйлчилгээг өргөжүүлж, номын сангийн үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, “Цахим номын сан” болгох ажлыг эрчимжүүлэн, гэрээр ном олгон гэртээ ном ашиглахыг дэмжин, номын фондын баяжилтыг нэмэгдүүлэх зорилгоор олон нийтийн сайн дурын хөдөлгөөнийг зохион байгуулна.

4.4. Иргэдийн биеийн тамир спортоор хичээллэх, аюулгүй таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, нийтээр дагаж мөрдөхөөр зарласан спортын хөтөлбөр, санал санаачилгыг дэмжинэ.



4.5. Залуучуудын байгууллагын санаачилгыг дэмжих, залуучуудын авьяас сонирхлыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд зориулсан төрөл бүрийн клуб байгуулах санал санаачилгыг дэмжинэ.

ТАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГО

5.1. Ажилгүй иргэдийг мэргэжил олгох болон давтан сургалтад хамруулан мэргэжлийн зөрүүгээс ажилгүйдэл үүсэх шалтгааныг бууруулна.

5.2. Нийтийг хамарсан хүмүүнлэгийн ажилд иргэдийг сайн дураар оролцох боломж мэдээллээр ханган ажиллана.

5.3. Үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэдийн нөхцөл байдлын судалгааг хийн төрөөс авч хэрэгжүүлэх бодлогод тусгуулах ажлыг зохион байгуулан ажиллана.

ЗУРГАА. ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГО

6.1. Талх, нарийн боов, гар урлал зэрэг үйлдвэрүүдийг шинээр байгуулахыг бодлогоор дэмжинэ.

6.2. Иргэд, хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн ахуйн үйлчилгээг үзүүлэх аж ахуйн нэгж, байгууллагыг бодлогоор дэмжин ажиллана.

6.3. Дүүргийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрийг байгуулах санал санаачилгыг дэмжинэ.

6.4. Эрүүл ахуйн шаардлага хангасан, орчин үеийн тохилог ахуй үйлчилгээ, худалдааны цогцолбор төв байгуулах саналыг дэмжинэ.

ДОЛОО. ДЭД БҮТЭЦ

7.1. Дүүрэг болон хорооны хөгжлийн хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажиллана.

7.2. Гэр хорооллын дахин төлөвлөлт, дэд төвүүдийг дэс дараатай байгуулна.

7.3. Гэр хорооллын айл өрхүүдийг хашаандaa тохилог амьдрах, байгальд ээлтгэй амьдрахад зориулсан төслийг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлэн, тохилог хороолол байгуулах ажлыг бодлогоор дэмжин эхлүүлнэ.

7.4. Ногоон байгууламж, гудамж, зам талбай, хүүхдийн тоглоомын талбай, гэрэлтүүлгийн зураглал гарган тохижуулах, инженерийн шугам сүлжээ, үерийн далан байгуулах зэрэг хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

7.5. Суурьшлын бүсэд Цахилгаан эрчим хүч, дэд бүтэцтэй зэрэг иргэдийн амьдрах орчин нөхцөл хангасан суурьшлын бүсийг бий болгох талаар судлан шийдвэрлэнэ.

7.6. Хөрсний болон үерийн уснаас хамгаалах арга хэлбэрийг иргэдэд сурталчлан таниулах ажлыг хийнэ.

7.7. Замын дагуу гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах талаар холбогдох байгууллагуудыг шаардлагыг хүргүүлэн ажиллана.

1117145633
УХА0612 9077278

БНЛ

7.8. Аж ахуйн нэгж байгууллагын хаяг, рекламыг шинэчлэх, гадна орчиндоо гэрэлтүүлэгтэй болгох, айл өрхийн хашаа, барилга байгууламжуудын өнгө үзэмжийг сайжруулах талаар уриалтыг гарган ажиллана.

7.9. Газар өмчлөөгүй иргэн бүрд өмчлүүлэхэд шаардлагатай газрын хэмжээг тодорхойлж, байришлыг тогтоон төлөвлөлт хийж газар өмчлөлийн хуулийн сурталчилгаа таниулгыг зохион байгууна.

7.10. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулна.

НАЙМ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО

8.1. Албан байгууллага, айл өрхийн хог хаягдлыг төрөлжүүлэн ялгах, зайлуулах, булж дарах ажлыг цогцоор нь шийдвэрлэж, агаарын болон хөрсний бохирдлыг бууруулж, Золбин нохой, муур устгах хүн амыг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

8.2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажил эрхэлж байгаа иргэд, нутгийн иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих, түгээмэл тархацтай байгалийн нөөц баялгийн ашиглалтад тавих хяналтыг сайжруулна

8.3. Хог хаягдлын цэгийг булслах, нөхөн сэргээх ажлын бүтэц зохион байгуулалтыг бий болгоно.

8.4. Мод үржүүлгийн газар шинээр байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

8.5. Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хяналт шалгалтыг тогтмолжуулан хууль бус үйлдлүүдийг таслан зогсоно.

ЕС. НУТГИЙН ЗАХИРГААНЫ ХҮРЭЭНД

9.1. Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангаж, төрийн албан хаагчийн ажлын хариуцлага ёс зүйг дээшлүүлнэ.

9.2. Төрийн албан хаагчийг гадаад, дотоодын хэрэгцээт сургалтад хамруулах, мэргэшүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулна.

9.3. “Иргэний танхим”ийн үйл ажиллагааг сайжруулж, иргэдийн санал бодлыг байнга сонсож төрийн бодлогод тусгана.


9.4. Төрийн захиргааны албан хаагчийн ажлын туршлага, ур чадварын түвшин нь харгалzan сэлгэн ажиллуулах, шатлан дэвших зарчмаар албан тушаал дэвшиүүлэх, төрийн жинхэнэ болон үйлчилгээний албаны удирдах ажилтныг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр нөхөн нөхцөлийг хангана.

9.5. Төрийн захиргааны албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан үндсэн чиг үүрэг, мэдлэг, ур чадвар, хариуцлага, ёс зүйн түвшин тогтоох үзлэгийг зохион байгуулж, үнэлгээнд тулгуурлан ажил сайжруулах, зөрчил арилгах чиглэлээр олон талт арга хэмжээ зохион байгуулна.

9.6. Төрийн байгууллагуудын цахим сүлжээг ашиглан иргэдэд мэдээлэл хүргэсэн байдал, цахим хуудасны баяжилтын талаар хяналт тавьж зөвлөгөө өгч байгууллагын ил тод байдлыг хангуулна.

9.7. Хороодод тулгамдсан асуудлыг хорооны иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж төрийн бодлого шийдвэр, цаг үеийн шуурхай мэдээллийг иргэдэд тогтмол хүргэнэ.

АРАВ. ХУНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД



10.1. Хууль, эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны ажлыг тогтмолжуулан, иргэдийн эрх зүйн боловсролыг сайжруулна.

10.2. Хүнийг эрхийг хангахад нутгийн захиргаа, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

10.3. Иргэд болон авлигатай тэмцэх төрийн бус байгууллагын сүлжээтэй хамтран авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлж, авлигагүй орчин бүрдүүлж ажиллана. Авлига, ашиг сонирхлын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлын хэрэгжилтийг хангуулах ажлыг эрчимжүүлнэ.

10.4. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг жил бүр батлуулан хэрэгжүүлнэ.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ

/Д.БАЯРЦОГТ/

_____oOo_____

